

Өгөгдөл хамгаалах тухай хуулийн үзэл баримтлал

Энэ хуулийн үйлчлэлд иргэдийн хувийн мэдээллийг эзэмшиж, ашиглаж, боловсруулж, дамжуулж буй бүх хуулийн этгээд, хувь хүмүүс хамаарагдана. Энэ хуулийн дагуу улсын бүртгэлийн өгөгдөл, өөрийн ажилтан, үйлчлүүлэгч, хэрэглэгч, түншүүдийн талаар хувийн өгөгдлийг эзэмшиж буй аливаа байгууллага уг мэдээлэл, мэдээллийн сангийн нууцлал, хамгааллыг хангах ёстой. Хуулийн заалтыг зөрчсөн байгууллагын тусгай эрхийг цуцлах болон удирдлагад нь арга хэмжээ авах, хувийн мэдээлэл нь алдагдсан иргэний зүгээс шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх боломжийг хууль тусгаж өгсөн болно. Түүнээс гадна уг хуулийн шаардлагуудыг зөрчсөн этгээд иргэний, эрүүгийн, захиргааны, сахилгын болон хууль тогтоомжоор заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Энэ хууль батлагдсан тохиолдолд байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлаа хангах, хувийн өгөгдлийн нууцлал, хамгааллыг хангахын тулд мэдээллийн технологийн шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бизнес үйл явцаа өөрчлөх шаардлага тулгарч байна.

Монгол улсад “Хувь хүний өгөгдлийг хамгаалах” зайлшгүй шаардлага тулгараад байна. Хувийн өгөгдөл хамгаалалтгүй, байнга гадагш урсаж байгаа нь хүмүүсийн түгшүүрийг төрүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ӨГӨГДӨЛ ХАМГААЛАХ ТУХАЙ

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1-р зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2-р зүйл. Хуулийн зорилт

3-р зүйл. Хууль ашигласан нэр томъёоны ойлголт

4-р зүйл. Өгөгдөл хамгаалах хууль тогтоомж

Хоёрдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗАРЧИМ, ҮНДСЭН НӨХЦӨЛ

5-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах зарчим

6-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах нөхцөл

7-р зүйл. Хувийн өгөгдлийн нууцлал

8-р зүйл. Хувийн өгөгдлийн нийтэд хүртээлтэй эх сурвалж

9-р зүйл. Өөрийн тухай өгөгдлийг боловсруулахыг зөвшөөрсөн хувийн өгөгдлийн эзний зөвшөөрөл

10-р зүйл. Хувийн өгөгдлийн тусгай төрлүүд

11-р зүйл. Хүний бие махбодийн үзүүлэлт дээр суурилсан хувийн өгөгдөл

12-р зүйл. Хувийн өгөгдлийг хил дамнан дамжуулах

13-р зүйл. Төрийн болон орон нутгийн удирдлагын байгууллагын мэдээллийн систем, улсын бүртгэлийн мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах нь.

Гуравдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДЛИЙН ЭЗНИЙ ЭРХ

14-р зүйл. Хувийн өгөгдлийн эзэн өөрийн тухай өгөгдөлд хандах эрх

15-р зүйл. Бараа, ажил үйлчилгээг зах зээлд сурталчлах болон улс төрийн зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулах үед өгөгдлийн эзний эдлэх эрх.

16-р зүйл. Хувийн өгөгдлийг автоматаар боловсруулах, бүртгэлийн ажиллагаанд ашиглах үед өгөгдлийн эзний эдлэх эрх

17-р зүйл. Операторын хууль бус үйлдлийн талаар гомдол гаргах

Дөрөвдүгээр бүлэг. ОПЕРАТОРЫН ҮҮРЭГ

18-р зүйл. Хувийн өгөгдөл цуглуулах үед операторын хүлээх үүрэг

19-р зүйл. Хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагааны аюулгүй байдал

20-р зүйл. Хувийн өгөгдлийг гаргаж өгөх талаар операторын хүлээх үүрэг

21-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах явцад гарсан зөрчлийг арилгах, хувийн өгөгдлийг тодруулах, хаах, устгах талаар операторын хүлээх үүрэг

22-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах тухай мэдэгдэх

Тавдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, ШАЛГАХ, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

23-р зүйл. Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалах эрх бүхий байгууллага

Зургаадугаар бүлэг. БУСАД

24-р зүйл. Хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага.

25-р зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Нэгдүгээр бүлэг. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1-р зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

- 1.1 Энэ хуулиар төрийн болон төрийн захиргааны байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, төрийн бусад байгууллага (цаашид - төрийн байгууллага), хуулийн этгээд, хувь хүмүүс мэдээллийн систем ашиглаж болон ашиглалгүйгээр хувь хүний тухай (цаашид хувийн өгөгдөл) өгөгдлийг боловсруулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэ хуулийн үйлчлэл нь дараах тохиолдлуудад хамаарахгүй:
 - 1.2.1 Хувь хүмүүс өөрсдийн хувийн болон гэр бүлийн хэрэгцээ шаардлагын дагуу хувийн өгөгдлийг боловсруулах. Ингэж боловсруулах үед хувийн өгөгдлийн эзний эрх зөрчигдсөн байж болохгүй.
 - 1.2.2 Архивын тухай хууль тогтоомжийн дагуу архивын фондуудад байгаа хувийн өгөгдөл агуулсан баримт бичгүүдийг хадгалах, зохион байгуулах, бүрдүүлэх, бүртгэх болон ашиглах.
 - 1.2.3 Төрийн нууцыг бүрдүүлж буй мэдээлэлд хамаарагдах хувийн өгөгдлийг боловсруулах

2-р зүйл. Хуулийн зорилт

- 2.1 Энэ хуулийн зорилт нь хувь хүн, иргэний хувийн өгөгдлийг боловсруулах үед эрх, эрх чөлөөг нь хангах, түүний дотор хувийн амьдрал, нэр төрийн халдашгүй байдал, гэр бүлийн нууцыг хамгаалахад оршино.

3-р зүйл. Хуулийн нэр томъёо

- 3.1 Хуулийн зорилтыг хангахын тулд энэ хуулинд дараах нэр томъёо-ойлголтыг ашигласан болно.
 - 3.1.1 Хувийн өгөгдөл гэж тодорхой хувь хүнд (хувийн өгөгдлийн эзэн) хамаарах мэдээллүүд, тухайлбал овог, нэр, төрсөн огноо, хаяг, гэр бүл, нийгэм, эд хөрөнгийн байдал, боловсрол, мэргэжил, орлого болон бусад шинжүүдийн тухай мэдээллийг хэлнэ.
 - 3.1.2 Оператор гэж хувийн өгөгдлийг боловсруулж, зохион байгуулж байгаа, түүнчлэн хувийн өгөгдлийг боловсруулах зорилго агуулгыг тодорхойлж байгаа төрийн болон нутгийн удирдлагын байгууллага, хуулийн этгээд, хувь хүмүүсийг хэлнэ.
 - 3.1.3 Хувийн өгөгдлийг боловсруулах гэж хувийн өгөгдөлтэй ажиллах ажиллагаа, түүний дотор хувийн өгөгдлийг цуглуулах, системчлэх, хуримтлуулах, хадгалах, тодруулах, шинэчлэх, өөрчлөх, ашиглах, тараах, дамжуулах, эзэнгүй болгох, хаах, устгах ажиллагааг хэлнэ.
 - 3.1.4 Хувийн өгөгдлийг тараах гэж хувийн өгөгдлийг тодорхой хүрээний хүмүүст дамжуулж өгөх, эсхүл хувийн өгөгдлийг олон нийтэд танилцуулах, түүний дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээнд тавих, эсхүл түүнд ямар нэг аргаар хандах хандалт олгохыг хэлнэ.
 - 3.1.5 Хувийн өгөгдлийг дамжуулах гэж хувийн өгөгдлийг операторуудын хооронд, оператор үйлчлүүлэгчийн хооронд болон төрөл бүрийн үйлчилгээний хооронд мэдээлэл, харилцаа, холбооны сүлжээ ашиглан шилжүүлэхийг хэлнэ.
 - 3.1.6 Хувийн өгөгдлийг ашиглах гэж шийдвэр гаргах, үйлчилгээ үзүүлэх болон хууль зүйн үр дагавар үүсгэж буй, эсхүл хувийн өгөгдлийн эзний эрх, эрх чөлөөг ямар

нэг байдлаар хөндөж буй бусад үйлдлийг хийхийн тулд операторын хэрэгжүүлж буй хувийн өгөгдөлтэй ажиллах ажиллагааг хэлнэ.

- 3.1.7 Хувийн өгөгдлийг хаах гэж хувийн өгөгдлийг цуглуулах, системчлэх, хуримтлуулах, тараах, дамжуулах ажиллагааг түр хугацаагаар зогсоохыг хэлнэ.
- 3.1.8 Хувийн өгөгдлийг устгах гэж мэдээллийн систем дахь хувийн өгөгдлийн агуулгыг дахин сэргээх боломжгүй болгож арилгах, хувийн өгөгдөл агуулж буй материаллаг тээгчийг устгах үйл ажиллагааг хэлнэ.
- 3.1.9 Хувийн өгөгдлийг эзэнгүй болгох гэж хувийн өгөгдөл чухам хэнд хамаарагдаж байгааг тодорхойлох боломжгүй болгох үйл ажиллагааг хэлнэ.
- 3.1.10 Хувийн өгөгдлийн мэдээллийн систем гэж хувийн өгөгдлийн санг агуулсан мэдээллийн систем болон тэдгээр өгөгдлийг боловсруулах зориулалттай мэдээллийн технологи, техник хэрэгслийн нэгдлийг хэлнэ.
- 3.1.11 Хувийн өгөгдлийн нууцлал гэж хувийн өгөгдлийн эзний зөвшөөрлийг авахгүйгээр юмуу хууль зүйн ямар нэг үндэслэл байхгүйгээр хувийн өгөгдлийг тараахгүй байх талаар операторууд болон хувийн өгөгдлийг ашиглаж буй, түүнд хандах эрх авсан этгээдийн заавал даган мөрдөх шаардлагуудыг хэлнэ.
- 3.1.12 Хувийн өгөгдлийг хил дамнуулан дамжуулах гэж операторууд хувийн өгөгдлийг Монгол улсын хилийг дамнуулан гадаад улсын төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүмүүст дамжуулахыг хэлнэ.
- 3.1.13 Нийтэд хүртээмжтэй хувийн өгөгдөл гэж хувийн өгөгдлийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр, эсхүл нууцлалыг хангах хууль зүйн шаардлагуудад хамаарахгүй учир олон нийтийн зүгээс хандаж болох эрхийг нь олгосон хувийн өгөгдлүүдийг хэлнэ.

4-р зүйл. Өгөгдөл хамгаалах хууль тогтоомж

- 4.1 Өгөгдөл хамгаалах тухай Монгол улсын хууль тогтоомж нь Үндсэн Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд суурилах бөгөөд энэ хууль болон хувийн өгөгдөл боловсруулах ажиллагааг зохицуулсан бусад хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актуудаас бүрдэнэ.
- 4.2 Энэ хууль дээр үндэслэн, түүнийг хэрэгжүүлэх үүднээс төрийн эрх бүхий байгууллагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хувийн өгөгдлийг боловсруулах тодорхой асуудлаар эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт батлан гаргаж болно. Хувийн өгөгдөл боловсруулахтай холбоотой эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд нь өгөгдлийн эзний эрхийг хязгаарласан заалтууд агуулж болохгүй. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон эдгээр акт нь нууцлалын зэрэглэлд хамаарахгүй бол заавал хэвлэн нийтлэгдэж байна.
- 4.3 Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр тусгасан бол олон улсын гэрээг даган мөрдөнө.

Хоёрдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЗАРЧИМ, НӨХЦӨЛ

5-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах зарчим

- 5.1 Хувийн өгөгдөл боловсруулах ажиллагаа дараах зарчмууд дээр тулгуурлан хэрэгжинэ:
 - 5.1.1 Хувийн өгөгдөл боловсруулах зорилго, арга хууль ёсны, шударга байх;

- 5.1.2 Хувийн өгөгдлийг боловсруулах зорилго нь хувийн өгөгдөл цуглуулах үед тодорхойлсон, зарласан зорилго болон операторын бүрэн эрхтэй нийцэж байх;
 - 5.1.3 Боловсруулж буй хувийн өгөгдлийн хэмжээ, шинж, ашиглаж буй арга нь боловсруулах зорилготой нийцэж байх;
 - 5.1.4 Хувийн өгөгдөл үнэ зөв байх, боловсруулах зорилгод хүрэлцэхүйц хангалттай байх;
 - 5.1.5 Хувийн өгөгдлийг цуглуулах үед зарласан зорилгоос хэтэрсэн өгөгдлийг боловсруулахгүй байх;
 - 5.1.6 Хоорондоо үл нийцэх зорилго бүхий хувийн өгөгдлийн сан, мэдээллийн системийг үл нэгтгэх.
- 5.2 Хувийн өгөгдлийн эзнийг тодорхойлох боломжтой хэлбэрээр хувийн өгөгдлийг хадгална. Хувийн өгөгдлийг боловсруулалтын зорилгоор тодорхойлогдож буй хугацаанд хадгалах бөгөөд уг хугацаа дууссаны дараа устгах юмуу хууль тогтоомжид заасны дагуу цахим хэлбэрээр архивлана.

6-р зүйл. Хувийн өгөгдөл боловсруулах нөхцөл

- 6.1 Энэ зүйлийн 2-г зааснаас бусад тохиолдолд хувийн өгөгдлийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр операторууд хувийн өгөгдлийг боловсруулж болно.
- 6.2 Дараах тохиолдолд энэ зүйлийн 1-д заасан хувийн өгөгдлийн эзний зөвшөөрөл шаардагдахгүй:
 - 6.2.1 Монгол улсын хуулиар хувийн өгөгдлийн эзэн, хувийн өгөгдлийг цуглуулах зорилго, нөхцөл, операторуудын бүрэн эрхийг тогтоосны дагуу хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 6.2.2 Нэг тал нь хувийн өгөгдлийн эзэн болж буй гэрээг биелүүлэх зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 6.2.3 Хувийн өгөгдлийг эзэнгүй болгосны үндсэн дээр статистикийн болон шинжлэх ухааны зорилгоор боловсруулах;
 - 6.2.4 Өгөгдлийн эзний зөвшөөрлийг авах боломжгүй үед амь нас, эрүүл мэнд болон бусад онцгой чухал ашиг сонирхлыг хамгаалах шаардлагын дагуу хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 6.2.5 Шуудан хүргэх, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх, тооцоо хийх, өргөдөл гомдлыг авч хэлэлцэх үед хувийн өгөгдөл боловсруулах;
 - 6.2.6 Хувийн өгөгдлийн эзний эрх, эрх чөлөөг зөрчилгүйгээр сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, уран зохиол, уран бүтээлийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 6.2.7 Монгол улсын хуулийн дагуу олон нийтэд зарлах, нийтлэх ёстой хувийн өгөгдлийг, түүний дотор төрийн албан тушаал эрхэлж байгаа этгээд, сонгуулийн албан тушаалд горилогсдын хувийн өгөгдлийг боловсруулах.
- 6.3 Хувийн өгөгдлийн онцгой төрлүүд, бие махбодийн үзүүлэлт (биометрик) дээр тулгуурласан хувийн өгөгдөл боловсруулах онцлогийг энэ хуулийн 10, 11-р зүйлд зааснаар зохицуулна.

6.4 Оператор гэрээний үндсэн дээр хувийн өгөгдөл боловсруулах ажиллагааг гуравдагч этгээдэд шилжүүлэх бол хувийн өгөгдлийн нууцлал, боловсруулалтын аюулгүй байдлыг хангах гуравдагч этгээдийн үүргийг гэрээнд заавал тусгана.

7 дугаар зүйл. Хувийн өгөгдлийн нууцлал

7.1 Хувийн өгөгдөлд хандах эрх олж авсан оператор, гуравдагч этгээдүүд энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд хувийн өгөгдлийн нууцлалыг хангасан байна.

7.2 Дараах тохиолдолд хувийн өгөгдлийн нууцлалыг хангах шаардлага үйлчлэхгүй:

7.2.1 Хувийн өгөгдлийг эзэнгүй болгосон бол;

7.2.2 Нийтэд хүртээмжтэй хувийн өгөгдөл бол.

8 дугаар зүйл. Хувийн өгөгдлийн нийтэд хүртээмжтэй эх сурвалжууд

8.1 Мэдээллийн үйлчилгээний зорилгоор хувийн өгөгдлийн нийтэд хүртээмжтэй (түүний дотор лавлахууд, хаягийн лавлах) эх сурвалжийг үүсгэж болно. Хувийн өгөгдлийн нийтэд хүртээмжтэй эх сурвалжид өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрлийн дагуу түүний овог, нэр, төрсөн огноо, газар, хэрэглэгчийн дугаар, мэргэжлийн мэдээлэл болон өгөгдлийн эзний гаргаж өгсөн бусад мэдээллийг оруулж болно.

8.2 Өгөгдлийн эзний шаардлага болон шүүхийн шийдвэр, эрх бүхий бусад байгууллагын шийдвэрийн дагуу аль нэг субъектийн тухай өгөгдлийг хувийн өгөгдлийн нийтэд хүртээмжтэй эх сурвалжаас дурын үед хасаж болно.

9 дүгээр зүйл. Өөрийн хувийн өгөгдлийг боловсруулах тухай өгөгдлийн эзний зөвшөөрөл

9.1 Энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд өгөгдлийн эзэн өөрийн хүсэл зориг, ашиг сонирхлын дагуу хувийн өгөгдлөө өгөх тухай шийдвэрээ гаргаж түүнийг боловсруулах зөвшөөрлийг өгнө. Хувийн өгөгдлийг боловсруулах тухай зөвшөөрлөө өгөгдлийн эзэн дурын үед буцаан татаж болно.

9.2 Үндсэн хуулийн байгуулал, нийгмийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, батлан хамгаалалт, аюулгүй байдлыг хангахын тулд өгөгдлийн эзэн өөрийн хувийн өгөгдлөө заавал өгөх тохиолдлуудыг энэ хууль болон Монгол улсын бусад хуулиудаар тодорхойлно.

9.3 Хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрлийг өгөгдлийн эзнээс авсан гэдгийг нотлох үүргийг оператор хүлээнэ.

9.4 Энэ хуулинд заасан тохиолдолд өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хувийн өгөгдлийг боловсруулна. Өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрөлд дараах мэдээллийг оруулсан байна:

9.4.1 Овог нэр, хаяг, иргэний ухаалаг үнэмлэхний дугаар, уг үнэмлэхийг олгосон огноо, байгууллага.

9.4.2 Өгөгдлийг боловсруулах зөвшөөрөл авсан операторын нэр, хаяг (овог, нэр).

9.4.3 Хувийн өгөгдлийг боловсруулах зорилго.

9.4.4 Зөвшөөрлийн дагуу боловсруулах гэж буй хувийн өгөгдлийн жагсаалт.

9.4.5 Зөвшөөрөл өгөгдсөн хувийн өгөгдлийг боловсруулах арга, хийх ажиллагаа.

9.4.6 Зөвшөөрлийн үйлчлэх хугацаа, түүнийг буцаан татах журам.

9.5 Бичгийн хэлбэрээр зөвшөөрөл олгосон хувийн өгөгдлийг боловсруулахад өөр зөвшөөрөл шаардагдахгүй.

9.6 Хувийн өгөгдлийн эзэн эрх зүйн чадамжгүй тохиолдолд түүний хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрлийг хууль ёсны төлөөлөгч нь бичгийн хэлбэрээр өгнө.

9.7 Хувийн өгөгдлийн эзэн нас барсны дараа түүний хувийн өгөгдлийг боловсруулах шаардлагатай болбол боловсруулах зөвшөөрлийг хууль ёсны өвлөгч нь өгнө.

10 дугаар зүйл. Хувийн онцлог өгөгдлүүд

10.1 Энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд яс үндэс, арьс өнгө, улс төр, шашин, гүн ухааны итгэл үнэмшил, эрүүл мэндийн байдал, хувийн амьдралтай холбоотой хувийн онцлог өгөгдлийг боловсруулахыг хориглоно.

10.2 Дараах тохиолдолд энэ зүйлийг 1-д заасан хувийн онцлог өгөгдлийг боловсруулж болно:

10.2.1 Өөрийн хувийн онцлог өгөгдлийг боловсруулах бичгийн зөвшөөрлийг өгөгдлийн эзэн өгсөн бол;

10.2.2 Хувийн онцлог өгөгдөл нь нийтэд хүртээмжтэй өгөгдөл бол;

10.2.3 Өгөгдлийн эзний амь нас, эрүүл мэнд болон амьдралын амин чухал ашиг сонирхол, эсхүл бусад этгээдийн амь нас, эрүүл мэнд, амьдралын амин чухал ашиг сонирхлыг хамгаалахын тулд түүний эрүүл мэндтэй холбоотой хувийн онцлог өгөгдлийг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарсан, өгөгдлийн эзний зөвшөөрлийг авах боломжгүй байгаа бол;

10.2.4 Хууль тогтоомжийн дагуу анагаах эмчлэх үйл ажиллагаа эрхэлдэг, эмчийн нууцыг хадгалах үүрэг хүлээсэн этгээд эмчилгээ-урьдчилан сэргийлэх, оношлох, эмнэх, анагаах үйлчилгээний зорилгоор хувийн онцлог өгөгдлийг боловсруулж байгаа бол;

10.2.5 Хууль тогтоомжийн дагуу, дүрэмд заасан зорилгодоо хүрэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, шашны байгууллага өөрийн гишүүдийн (оролцогчид) хувийн өгөгдлийг гадагш тараалгүйгээр боловсруулж байгаа бол;

10.2.6 Шүүх засаглалын үйл ажиллагаа явуулахтай холбоотойгоор хувийн онцлог өгөгдлийг боловсруулж байгаа бол;

10.2.7 Үндэсний Аюулгүй Байдал, батлан хамгаалах, гүйцэтгэх ажил, шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу хувийн онцлог өгөгдлийг боловсруулж байгаа бол.

10.3 Ял шийтгэлийн тухай хувийн өгөгдлийг хуулиар эрх олгогдсон төрийн байгууллага, бусад этгээд боловсруулна.

10.4 Энэ зүйлийн 2 -т заасан хувийн онцлог өгөгдлийг боловсруулах шалтгаан арилсан тохиолдолд боловсруулах ажиллагааг нэн даруй зогсооно.

11 дүгээр зүйл. Хувийн биометр өгөгдөл

11.1 Хүний бие махбодийн онцлогийг илэрхийлсэн, түүн дээр тулгуурлан хувийн байдлыг тогтоох үндэслэл болсон хосгүй мэдээллийг (хувийн биометр өгөгдөл) энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрлийн үндсэн дээр боловсруулж болно.

11.2 Шүүх засаглалыг хэрэгжүүлэх болон улсыг аюулаас хамгаалах, шуурхай эрэн сурвалжлах, гүйцэтгэх ажил, төрийн алба, шүүхийн шийдвэр биелүүлэх, улсын хилээр орох, гарах, Улсын бүртгэлийн тухай Монгол улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд өгөгдлийн эзний зөвшөөрөлгүйгээр хувийн биометр өгөгдлийг боловсруулж болно.

12 дугаар зүйл. Хувийн өгөгдлийг улсын хил давуулан дамжуулах

12.1 Хувийн өгөгдлийг улсын хил давуулан дамжуулахын өмнө хувийн өгөгдлийг хүлээн авах улсад өгөгдлийн эзний эрхийг нэгэн адил хамгаалж байгаа эсэхийг оператор шалгасан байна. Хэрэв өгөгдлийн эзний эрхийг хамгаалж чадахгүй байна гэж үзвэл хувийн өгөгдлийг дамжуулахгүй.

12.2 Өгөгдлийн эзний эрхийг зохих ёсоор хамгаалдаг улсад хууль тогтоомжийн дагуу хувийн өгөгдлийг дамжуулж болохоос гадна Үндсэн хуулийн байгуулал, иргэдийн эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хориглох юмуу хязгаарлаж болно.

12.3 Өгөгдлийн эзний эрхийг зохих ёсоор хангаж чадахгүй байгаа улсад хувийн өгөгдлийг дараах тохиолдолд шилжүүлж болно:

12.3.1 Хувийн өгөгдлийн эзэн бичгээр зөвшөөрөл гаргасан бол;

12.3.2 Виз олгох, иргэн, эрүү, гэр бүлийн хэргээр эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай Монгол Улсын олон улсын гэрээгээр заагдсан бол;

12.3.3 Монгол Улсын Үндсэн Хуулийн байгууллыг хамгаалах, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах чадварыг хангах шаардлагаар хуулинд заагдсан бол;

12.3.4 Хувийн өгөгдлийн эзэн нэг тал нь болж буй гэрээг биелүүлэхийн тулд;

12.3.5 Өгөгдлийн эзэн болон бусад этгээдийн амь нас, эрүүл мэнд, бусад амин чухал ашиг сонирхлыг хамгаалах шаардлага тулгарсан үед өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрлийг авах боломжгүй тохиолдолд;

13 дугаар зүйл. Төр, нутгийн удирдлагын мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах

13.1 Улсын бүртгэл хөтлөх, төрийн үйлчилгээ үзүүлэх болон бусад зорилгоор төрийн болон нутгийн удирдлагын байгууллагууд хувийн өгөгдөл боловсруулах мэдээллийн системийг хуулиар тогтоосон эрх мэдлийнхээ хүрээнд байгуулж болно.

13.2 Төр, нутгийн удирдлагын мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах, түүний дотор өгөгдлийн хамаарлыг тодорхойлох төрөл бүрийн арга ашиглах онцлогийг хуулиар тогтоож болно.

13.3 Төр, нутгийн удирдлагын мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах, өгөгдлийн хамаарлыг тодорхойлох төрөл бүрийн арга ашиглахтай холбоотой үндэслэлээр хүн, иргэний эрх, эрх чөлөө хязгаарлагдаж болохгүй. Хүний нэр төр, алдар хүндийг гутаасан арга ашиглахыг хориглоно.

13.4 Төр, нутгийн удирдлагын мэдээллийн системд хувийн өгөгдөл боловсруулах үед өгөгдлийн эзний эрхийг хангах зорилгоор хувийн өгөгдлийн нэгдсэн бүртгэл-жагсаалт үүсгэж болно.

Гуравдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДЛИЙН ЭЗНИЙ ЭРХ

14 дүгээр зүйл. Өгөгдлийн эзэн өөрийн хувийн өгөгдөлд хандах эрх

- 14.1 Хувийн өгөгдлийн эзэн өгөгдлийг боловсруулж буй оператор, түүний хаяг, байрлал, мэдэлд нь байгаа өөрийн тухай өгөгдлийн тухай мэдээллийг авах, энэ зүйн 5-д зааснаас бусад тохиолдолд өөрийн тухай өгөгдөлдөө хандах, танилцах эрхтэй. Хэрэв хувийн өгөгдөл нь бүрэн бус, хуучирсан, худал, хууль бусаар олж авсан, боловсруулах зорилготойгоо нийцэхгүй байгаа бол өгөгдлийг тодруулах, засварлахыг оператороос шаардах, эрхээ хамгаалуулах хууль ёсны арга хэмжээ авах эрхийг өгөгдлийн эзэн эдэлнэ.
- 14.2 Хувийн өгөгдөл нь байгаа тухай мэдээллийг оператороос өгөгдлийн эзэнд хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ. Уг мэдээлэлд бусад этгээдэд хамааралтай хувийн өгөгдөл орсон байж болохгүй.
- 14.3 Өгөгдлийн эзэн юмуу түүний хууль ёсны төлөөлөгчөөс операторт ямар нэг хэлбэрээр хүсэлт гаргасан тохиолдолд хувийн өгөгдөлдөө хандах хандалтыг олгоно. Хүсэлт гаргах ажиллагааг цахим болон цахим бус аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.
- 14.4 Хувийн өгөгдлийн эзэн өөрийн хувийн өгөгдлийг боловсруулж байгаа тухай мэдээллийг, түүний дотор дараах өгөгдлийг агуулсан мэдээллийг авах эрхтэй:
- 14.4.1 Оператор түүний хувийн өгөгдлийг боловсруулж байгаа гэдгийг баталсан;
 - 14.4.2 Боловсруулалтын зорилго;
 - 14.4.3 Боловсруулж буй арга;
 - 14.4.4 Хувийн өгөгдөлд хандах эрхтэй этгээд;
 - 14.4.5 Боловсруулж буй хувийн өгөгдлийн жагсаалт, түүний эх сурвалж;
 - 14.4.6 Хувийн өгөгдлийг боловсруулах, хадгалах хугацаа;
 - 14.4.7 Хувийн өгөгдлийг нь боловсруулсны улмаас үүсэж гарах хууль зүйн үр дагавар;
- 14.5 Дараах тохиолдолд өгөгдлийн эзэн өөрийн тухай өгөгдөлд хандах эрхээ хязгаарлуулна:
- 14.5.1 Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, эрх зүйн дэг журмыг сахиулах зорилгоор хэрэгжүүлж буй шуурхай эрэн сурвалжлах, сөрөг тагнуул, тагнуулын үйл ажиллагааны үр дүнд олж авсан хувийн мэдээллийг боловсруулж байгаа бол;
 - 14.5.2 Сэжигтэн, яллагдагчийг хувийн өгөгдөлтэй нь танилцуулна гэж Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулинд зааснаас бусад тохиолдолд өгөгдлийг эзнийг гэмт хэрэгт сэжиглэж саатуулсан, эрүүгийн хэрэгт ял сонсгосон, ял сонсгохоос өмнө таслан сэргийлэх арга хэмжээ авч буй байгууллага хувийн өгөгдлийг боловсруулж байгаа бол;
 - 14.5.3 Хувийн өгөгдөлд хандах нь бусад этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа бол.
- 15 дугаар зүйл. Бараа, ажил үйлчилгээг зах зээлд сурталчлах, улс төрийн суртал ухуулга хийх зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулах үед өгөгдлийн эзний эдлэх эрх**
- 15.1 Холбооны хэрэгсэл ашиглан хэрэглэгчтэй шууд харилцах замаар бараа, ажил үйлчилгээг зах зээлд сурталчлах, түүнчлэн улс төрийн суртал ухуулгын зорилгоор хувийн өгөгдлийг боловсруулахад өгөгдлийн эзний зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

15.2 Өгөгдлийн эзэн шаардлага тавьсан тохиолдолд оператор энэ зүйлийн 1-д заасан зорилгоор хувийн өгөгдөл боловсруулах ажиллагаагаа нэн даруй зогсооно.

16 дугаар зүйл. Хувийн өгөгдлийг автоматаар боловсруулах үед өгөгдлийн эзний эдлэх эрх

16.1 Энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд хувийн өгөгдлийг автоматаар боловсруулсны үр дүнд өгөгдлийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж, хууль зүйн үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргахыг хориглоно.

16.2 Өгөгдлийн эзний бичгийн зөвшөөрлийн үндсэн дээр, эсхүл хуулиар заасан тохиолдолд өгөгдлийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хангасны үндсэн дээр хувийн өгөгдлийг автоматаар боловсруулсны үр дүнд тулгуурлан шийдвэр гаргаж болно.

16.3 Хувийн өгөгдлийг автоматаар боловсруулсны үр дүнд тулгуурлан шийдвэр гаргах журам, түүнээс гарах үр дагаварыг оператор өгөгдлийн эзэнд тайлбарлаж өгөх үүрэгтэй. Уг шийдвэрийг эсэргүүцэх боломжоор хангахаас гадна эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах журмыг оператор өгөгдлийн эзэнд тайлбарлаж өгөх үүрэгтэй.

16.4 Энэ зүйлийн 3-т заасан эсэргүүцлийг оператор хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор заавал авч хэлэлцэж үр дүнг нь өгөгдлийн эзэнд мэдэгдэнэ.

17 угаар зүйл. Операторын үйлдэл, эс үйлдлийн талаар гомдол гаргах эрх

17.1 Оператор энэ хууль болон бусад хуулийн шаардлагыг зөрчиж, эсхүл ямар нэг байдлаар эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонихлыг зөрчсөн байдлаар хувийн өгөгдлийг боловсруулж байна гэж үзэх үндэслэл байгаа бол операторын үйлдэл, эс үйлдлийн талаар эрх бүхий байгууллага, шүүхэд өгөгдлийн эзэн гомдол гаргах эрхтэй.

17.2 Өгөгдлийн эзэн өөрийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирол болон ёс суртахууны хохирлыг шүүхийн журмаар гаргуулах авах эрхтэй.

Дөрөвдүгээр бүлэг. ОПЕРАТОРЫН ҮҮРЭГ

18 дугаар зүйл. Хувийн өгөгдөл цуглуулах үед операторын хүлээх үүрэг

18.1 Оператор хувийн өгөгдөл цуглуулж байгаа үедээ өгөгдлийн эзнээс хүсэлт гаргасан тохиолдолд энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 4-т заасан мэдээллийг гаргаж өгнө.

18.2 Хэрэв Монгол улсын хуулиар хувийн өгөгдлөө гаргаж өгөх үүрэг тогтоосон бол хувийн өгөгдлөө өгөхөөс татгалзахын хууль зүйн үр дагаварыг өгөгдлийн эзэнд оператор тайлбарлаж өгнө.

18.3 Монгол улсын хуулийн дагуу гаргаж өгсөн, эсхүл уг хувийн өгөгдөл нийтэд хүртээмжтэй байгаагаас бусад тохиолдолд хувийн өгөгдлийг эзнээс нь хүлээн аваагүй бол дараах мэдээллийг өгөгдлийн эзэнд заавал мэдэгдэнэ:

18.3.1 Оператор юмуу түүний төлөөлөгчийн нэр, хаяг;

18.3.2 Хувийн өгөгдлийг боловсруулах зорилго, эрх зүйн үндэслэл;

18.3.3 Хувийн өгөгдлийг ашиглах этгээдүүд;

18.3.4 Хувийн өгөгдлийн эзний хуулиар тогтоосон эрх.

19 дүгээр зүйл. Хувийн өгөгдлийг боловсруулах үед аюулгүй байдлыг нь хангах

19.1 Оператор хувийн өгөгдөл боловсруулахдаа Мэдээллийн Аюулгүй Байдлын хуулинд заагдсан удирдлага, зохион байгуулалт, дэг, програм-техникийн арга хэмжээ, түүний дотор хувийн өгөгдөлд хууль бусаар болон санамсаргүй хандах, устгах, өөрчлөх, бусниулах, хуулбарлах, хаах, тараахаас хамгаалах, бусад хууль бус үйлдлээс хамгаалахын тулд шифрлэх (криптографын) хэрэгсэл, орчин үеийн шийдлүүдийг хэрэгжүүлж ашиглана.

19.2 Хувийн өгөгдлийг боловсруулах үед аюулгүй байдлыг хангах шаардлага, хувийн өгөгдөл, биометр өгөгдлийн тээгч, хадгалах технологид тавигдах шаардлагыг Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор нарийвчлан тогтооно.

19.3 Энэ зүйлийн 2-т заасан шаардлагыг биелүүлж, хангаж буй байдалд Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Тагнуулын Ерөнхий газар хяналт тавина. Дээрх байгууллагууд хяналт тавих явцдаа хувийн өгөгдөлтэй танилцах эрхгүй.

19.4 Хувийн биометр өгөгдлийг мэдээллийн системээс гадуур ашиглах, хадгалахдаа өгөгдөлд хууль бусаар юмуу санамсаргүй хандах, устгах, өөрчлөх, бусниулах, хуулбарлах, хаах, тараахаас хамгаалах боломжийг бүрэн хангасан тээгч, хадгалах технологи ашиглана.

20 дугаар зүйл. Хувийн өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдний эрхийг хамгаалах эрх бүхий байгууллагаас хандсан, хүсэлт гаргасан тохиолдолд операторын хүлээх үүрэг

20.1 Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувийн өгөгдөл нь байгаа талаар өгөгдлийн эзэнд мэдэгдэхээс гадна өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгчөөс хандсан, хүсэлт гаргасан тохиолдолд хувийн өгөгдөлтэйгөө үнэ төлбөргүйгээр танилцах боломжоор хангах үүргийг оператор хүлээнэ.

20.2 Өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгчөөс хандсан хандалт, гаргасан хүсэлтэд татгалзах үндэслэл байвал уг үндэслэлийг тодорхой тусгасан татгалзсан хариуг оператор ажлын 7 хоногийн дотор бичгийн хэлбэрээр өгнө.

20.3 Хамаарагдах хувийн өгөгдөл нь хуучирсан, худал, бүрэн бус, хууль бусаар олж авсан юмуу боловсруулах зорилготойгоо нийцэхгүй байгаа талаар өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгчөөс мэдэгдсэний дагуу шалгах, хэрэв үндэслэлтэй бол хувийн өгөгдөлд өөрчлөлт оруулах, устгах, хаах үүргийг оператор хүлээнэ. Оператор оруулсан өөрчлөлт, хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгчид заавал мэдэгдэнэ.

20.4 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалах эрх бүхий байгууллагын хүсэлтээр уг байгууллагын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг оператор ажлын долоо хоногийн дотор гаргаж өгнө.

21 дүгээр зүйл. Хувийн өгөгдлийг боловсруулах үед гаргасан алдааг арилгах, хувийн өгөгдлийг тодруулах, хаах, устгах талаар операторын хүлээх үүрэг

21.1 Хувийн алдаатай өгөгдөл болон хувийн өгөгдлийг хууль бусаар боловсруулсныг илрүүлсэн тохиолдолд оператор уг өгөгдлийг хаах үүрэгтэй.

21.2 Хувийн алдаатай өгөгдлийг илрүүлсэн тохиолдолд өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгч юмуу өгөгдлийн эзний эрхийг хамгаалах байгууллагын гаргаж өгсөн нотлох баримтын үндсэн дээр оператор уг хувийн өгөгдлийг залруулан засаж, хаалтыг авна.

- 21.3 Хувийн өгөгдлийг хууль бусаар боловсруулсныг илрүүлсэн тохиолдолд илрүүлснээс хойш ажлын гурван хоногийн дотор оператор уг зөрчлийг заавал арилгана. Оператор уг зөрчлийг хуульд заасан хугацаанд арилгах боломжгүй бол хувийн өгөгдлийг устгана. Оператор зөрчлийг арилгасан юмуу хувийн өгөгдлийг устгасан тухайгаа өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгч, хүсэлт гаргасан байгууллагад ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 21.4 Хувийн мэдээллийг боловсруулах зорилго хангагдсан тохиолдолд оператор хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагааг нэн даруй зогсоож хуулинд өөрөөр заагаагүй бол хувийн өгөгдлийг ажлын гурван өдрийн дотор дахин сэргээгдэх боломжгүйгээр устгаж өгөгдлийн эзэн, түүний хууль ёсны төлөөлөгч, хүсэлт гаргасан байгууллагад энэ тухайгаа мэдэгдэнэ.
- 21.5 Хэрэв хууль болон өгөгдлийн эзэн операторын хооронд байгуулсан гэрээнд өөрөө заагаагүй бол өгөгдлийн эзэн өөрийн хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрлөө буцаан татсан тохиолдолд өгөгдөл боловсруулах ажиллагааг нэн даруй зогсоож уг өгөгдлийг дахин сэргээх боломжгүйгээр устгана. Оператор хувийн өгөгдлийг устгасан тухайгаа ажлын гурван хоногт багтаан өгөгдлийн эзэнд мэдэгдэнэ.

22 дугаар зүйл. Хувийн өгөгдөл боловсруулж байгаа тухай мэдэгдэх

- 22.1 Оператор хувийн өгөгдлийг боловсруулж эхлэхийн өмнө энэ зүйлийн 2-т зааснаас бусад тохиолдолд өгөгдлийн эзний эрхийг хамгаалах байгууллагад өгөгдөл боловсруулах тухайгаа заавал мэдэгдэнэ.
- 22.2 Дараах тохиолдолд оператор өгөгдлийн эзний эрхийг хамгаалах байгууллагад мэдэгдэлгүйгээр хувийн өгөгдлийг боловсруулж болно:
- 22.2.1 Оператортой хөдөлмөрийн харилцаанд орж буй этгээдэд хамааралтай хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 22.2.2 Өгөгдлийн эзэнтэй байгуулсан гэрээний дагуу олж авсан хувийн өгөгдлийг уг гэрээг биелүүлэх зорилгоор боловсруулах;
 - 22.2.3 Хууль тогтоомжийн дагуу, дүрэмд заасан зорилгодоо хүрэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, шашны байгууллага өөрийн гишүүдийн (оролцогчид) хувийн өгөгдлийг гадагш тараалгүйгээр боловсруулах;
 - 22.2.4 Нийтэд хүртээмжтэй хувийн өгөгдөл боловсруулах;
 - 22.2.5 Өгөгдлийн эзний овог, нэрийг оруулсан өгөгдлийг боловсруулах;
 - 22.2.6 Өгөгдлийн эзнийг нэг удаа нэвтрүүлэх зорилгоор хувийн өгөгдөл боловсруулах;
 - 22.2.7 Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан төрийн мэдээллийн систем, Үндэсний Аюулгүй Байдал, батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор байгуулагдсан төрийн мэдээллийн системд байгаа хувийн өгөгдлийг боловсруулах;
 - 22.2.8 Монгол улсын хуулийн дагуу төрийн удирдлага, үйлчилгээний зорилгоор цуглуулсан хувийн өгөгдлийг боловсруулах.
- 22.3 Энэ зүйлийн 1-д заасан мэдэгдлийг цаасан тээгч дээр бичгийн хэлбэрээр болон цахим хэлбэрээр илгээж болно. Цаасан тээгч дээрх мэдэгдлийг эрх бүхий этгээдийн гарын үсгээр, цахим мэдэгдлийг эрх бүхий этгээдийн тоон гарын үсгээр баталгаажуулна. Мэдэгдэлд дараах мэдээллийг оруулсан байна:
- 22.3.1 Операторын нэр, хаяг;

- 22.3.2 Хувийн өгөгдлийг боловсруулах зорилго;
 - 22.3.3 Хувийн өгөгдлийн төрөл;
 - 22.3.4 Хувийн өгөгдлийг нь боловсруулж буй этгээдийн төрөл;
 - 22.3.5 Хувийн өгөгдлийг боловсруулах эрх зүйн үндэслэл;
 - 22.3.6 Хувийн өгөгдөл дээр хийх ажиллагаа, боловсруулах аргын танилцуулга;
 - 22.3.7 Хувийн өгөгдлийг боловсруулах үед аюулгүй байдлыг нь хангахын тулд операторын хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт;
 - 22.3.8 Хувийн өгөгдлийг боловсруулж эхлэх огноо;
 - 22.3.9 Хувийн өгөгдлийг боловсруулах хугацаа, боловсруулалтыг дуусгах нөхцөл, огноо.
- 22.4 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалах байгууллага операторуудын бүртгэл хөтөлнө. Бүртгэлд энэ зүйлийн 3-т заасан мэдээллийг оруулна. Бүртгэлд оруулсан хувийн өгөгдлийн аюулгүй байдлыг хангахын тулд операторын хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдээллээс бусад мэдээлэл нийтэд хүртээмжтэй байна.
- 22.5 Хувийн өгөгдлийг боловсруулах тухай өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагад мэдэгдэл хүргэх, түүний операторын бүртгэлд оруулахтай холбогдон гарах зардлыг оператор хариуцна.
- 22.6 Энэ зүйлийн 3-т заасан мэдээллийг бүрэн бус, эсхүл худал гаргаж өгсөн тохиолдолд операторын бүртгэлд мэдээллийг оруулахын өмнө мэдээллийг тодруулах, бүрэн болгохыг өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага шаардах эрхтэй.
- 22.7 Энэ зүйлийн 3-т заасан мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд оператор ажлын 10 хоногийн дотор өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагад уг өөрчлөлтийн талаар мэдэгдэнэ.

Тавдугаар бүлэг. ХУВИЙН ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛЛАГААГ ХЯНАХ.

23 дугаар зүйл. Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага

- 23.1 Хувийн өгөгдлийг боловсруулах ажиллагаа энэ хуулийн шаардлагад нийцэж эсэхэд тавих хяналтыг хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага хэрэгжүүлнэ. Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага нь Мэдээллийн технологийн салбарт хяналт тавих чиг үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага байна.
- 23.2 Хувийн өгөгдлийн агуулга, түүнийг боловсруулах зорилго, аргын талаар өгөгдлийн эзнээс гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлыг өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага хүлээн авч, хянан хэлэлцэж, зохих шийдвэр гаргана.
- 23.3 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага дараах бүрэн эрхийг эдэлнэ:
- 23.3.1 Өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг хувь хүн, хуулийн этгээдээс шаардах, үнэ төлбөргүйгээр гаргуулан авах;
 - 23.3.2 Хувийн өгөгдөл боловсруулах тухай мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг шалгах, уг шалгалтанд бусад байгууллагыг татан оруулах;
 - 23.3.3 Хувийн буруу ташаа өгөгдөл, хууль бус замаар олж авсан хувийн өгөгдлийг засах, тодруулах, хаах, устгахыг оператороос шаардах;

- 23.3.4 Энэ хуулийн шаардлагыг зөрчин хэрэгжүүлж байгаа хувийн өгөгдөл боловсруулах ажиллагааг хуульд заасан журмын дагуу түдгэлзүүлэх, зогсоох арга хэмжээ авах;
- 23.3.5 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалсан нэхэмжлэлийг шүүхэд гаргах, өгөгдлийн эзний ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөх;
- 23.3.6 Энэ хуулийн шаардлагыг зөрчин хувийн өгөгдөл боловсруулж буй операторт зөрчлөө арилгах шаардлага тавих, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд операторт тусгай зөвшөөрөл олгодог байгууллагад хандан тусгай зөвшөөрлийг түвгэлзүүлэх, хүчингүй болгох хүсэлт тавих;
- 23.3.7 Хувийн өгөгдлийн эзний эрхийг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбоотой материалыг хууль хамгаалах байгууллагад илгээх;
- 23.3.8 Хувийн эзний өгөгдлийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг Засгийн Газарт оруулах;
- 23.3.9 Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдийг захиргааны хариуцлагад татах.
- 23.4 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад олж авсан хувийн өгөгдлийн нууцлалыг хангана.
- 23.5 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага дараах үүргийг хүлээнэ:
 - 23.5.1 Энэ хууль болон бусад хуулийн шаардлагын дагуу хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалах;
 - 23.5.2 Хувийн өгөгдөл боловсруулахтай холбоотой асуудлаар хувь хүн, хуулийн этгээдээс гаргаж буй өргөдөл, гомдлыг авч хэлэлцэх, өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах;
 - 23.5.3 Операторын бүртгэл хөтлөх;
 - 23.5.4 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, боловсронгуй болгох;
 - 23.5.5 Мэдээллийн аюулгүй байдлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Тагнуулын Ерөнхий газрын мэдээллийн дагуу хуулиар тогтоосон журмын дагуу хувийн өгөгдөл боловсруулах ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох арга хэмжээ авах;
 - 23.5.6 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалж буй байдлын талаар төрийн байгууллага, өгөгдлийн эзэнд мэдээлэх;
 - 23.5.7 Хуулиар тогтоосон бусад үүргийг биелүүлэх.
- 23.6 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагын шийдвэрийг шүүхийн журмаар давж заалдаж болно.
- 23.7 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага өөрийн үйл ажиллагааны тухай тайланг жил бүр УИХ, Засгийн Газарт гаргаж өгнө. Энэ тайланг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлнэ.
- 23.8 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- 23.9 Хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагын дэргэд нийгмийн бүх давхаргын төлөөллийг оруулсан 25 хүнтэй зөвлөлдөх хороог байгуулна. Зөвлөлдөх

хороог байгуулах журам, үйл ажиллагааны журмыг хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллага тогтооно.

Зургаадугаар бүлэг. БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- 24.1 Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд иргэн, эрүү, захиргаа, сахилгын болон хуулинд заасан бусад хариуцлага ногдуулна.
- 24.2 Хувийн өгөгдөл хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг шүүгч ногдуулна:
- 24.2.1 Хувийн өгөгдлийг хууль бусаар олж авсан, боловсруулсан албан тушаалтан, ажилтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.2 Хувийн өгөгдлийн нууцлалыг алдагдуулсан, дэлгэсэн албан тушаалтан, ажилтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.3 Мэдээллийн Аюулгүй Байдлын хуулинд заагдсан удирдлага, зохион байгуулалт, дэг, програм-техникийн арга хэмжээ, түүний дотор хувийн өгөгдөлд хууль бусаар болон санамсаргүй хандах, устгах, өөрчлөх, бусниулах, хуулбарлах, хаах, тараахаас хамгаалах, бусад хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй албан тушаалтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.4 Хувийн өгөгдөл цуглуулах үед хүлээх үүргээ биелүүлээгүй, биелүүлэхээс зайлсхийсэн албан тушаалтан, ажилтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.5 Хувийн өгөгдлийг автоматаар боловсруулсны үр дүнд өгөгдлийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж, хууль зүйн үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргасан албан тушаалтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.6 Хувийн өгөгдлийн эзний гаргасан хүсэлт, өргөдөл, гомдлыг зохих ёсоор хянаж, шийдвэр гаргаагүй, хариу өгөөгүй албан тушаалтныг - хүртэл төгрөгөөр торгох;
- 24.2.7 Хувийн өгөгдлийн эзний эрхийг хамгаалахад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, санаатайгаар гэмтээж устгасан, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн албан тушаалтныг - хүртэл төгрөгөөр торгох.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

- 25.1 Энэ хуулийг 2009 оны . . дүгээр сарын . .-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 25.2 Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө мэдээллийн системд оруулсан хувийн өгөгдлийг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн энэ хуулийн дагуу боловсруулна.
- 25.3 Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ажиллагаанд орсон хувийн өгөгдөл боловсруулдаг мэдээллийн системийг 2011 оны 01 дүгээр сарын 01 – нээс өмнө энэ хуулийн шаардлагад нийцүүлсэн байна.
- 25.4 Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хувийн өгөгдөл боловсруулж байсан, цаашид боловсруулах операторууд 2010 оны . . дүгээр сарын . . нээс өмнө хувийн өгөгдлийн эзний эрх хамгаалах байгууллагад мэдэгдлээ хүргүүлнэ.